

25



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 1108

Шивээговь сум

Эд хөрөнгө худалдаж авахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Хог тээврийн автомашинд 2 ширхэг аккумулятор худалдаж авахад 946,000 (есөн зуун дөчин зургаан мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Аккумулятор худалдаж авахад зарцуулагдах 946,000 (есөн зуун дөчин зургаан мянга) төгрөгийг БГБНАУТХураамж /Хог хаягдалтай холбоотой зардал/-аас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа), нярав (Б.Баярцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ОТГОНЖАРГАЛ